

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар




ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ЗЭЭЛ АВСАН ХОРШООД
ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХГҮЙ БАЙГААГААС
АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОХ, ИРГЭДИЙН ОРЛОГЫГ
НЭМЭГДҮҮЛЭХ, АМЬЖИРГААГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ
ХАНГАГДАХГҮЙ БАЙНА.**

“ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ, ЗЭЭЛИЙН
ЭРГЭН ТӨЛӨЛТ”-д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: ХЭА-2025/53-ШТА-ГА

Хэрлэн сум 2025 он



Газрын дарга, Тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар

Утас: 70562112 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Эрдэнэбилэг

Утас: 92116770 Цахим хаяг: erdenebilegd@audit.gov.mn

Аудитор Ц.Хатанболд

Утас: 91117325 Цахим хаяг: khatanboldts@audit.gov.mn

Аудитор Б.Ариунаа

Утас: 99195208 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn

Аудитор Б.Оюундарь

Утас: 99565533 Цахим хаяг: oyundarib@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



2025 оны 05 дугаар сарын 30

Дугаар А/24

Чингис хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, түүний үр дүн, үр нөлөө, зээлийн эргэн төлөлт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, хүргүүлсэн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газарт тус тус хүргүүлэхийг ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн албан шаардлагыг тогтоосон хугацаанд, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, түүний биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Аюурбуны/, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Г.Гантөмөр/-д тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ж.ГАНБААТАР

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	6
БҮЛЭГ 1. ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХОЛБОГДОХ ЖУРАМ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДААГҮЙ, ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ДУТМАГ БАЙГААГААС ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА .9	
1.1. Орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичигт хоршоог хөгжүүлэх талаар тодорхой тусгаагүй байна.	9
1.2 Сумдад тухайн асуудлыг хариуцсан хүний нөөц дутагдалтай, удирдлага зохион байгуулалт хангалтгүйгээс ХХС-ийн үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулах боломжгүй байна.....	10
1.3 Хяналтын зөвлөл нь хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.....	13
БҮЛЭГ 2.ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ЗЭЭЛ ОЛГОСОН ТӨСЛИЙН ҮР ДҮНД АЖЛЫН БАЙР НЭМЭГДЭХГҮЙ БАЙНА.....	13
2.1 Төсөл хэрэгжүүлэгч хоршоодын 49.1 хувь нь орон нутагт тогтвортой үйл ажиллагаа явуулахгүй байгаагаас ажлын байр нэмэгдэхгүй байна.	13
2.2 Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан боловч эх үүсвэрийг бүрэн ашиглахгүй байна.....	14
БҮЛЭГ 3. САНГИЙН ХУГАЦАА ХЭТЭРСЭН ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ НЬ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАНГАХГҮЙ БАЙНА.....	16
3.1 Сангийн нийт зээлийн үлдэгдлийн 58.0% буюу 3,224.5 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн зээл байна.	16
3.2 Сангийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хангалтгүй байна.	17
Холбогдох байгууллагын санал:	19
Саналд өгсөн тайлбар:.....	19
ДҮГНЭЛТ: 20	
ЗӨВЛӨМЖ:	21

	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР
ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЖДБДС	Жижиг дунд бизнесийг дэмжих сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СХС	Сум хөгжүүлэх сан
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ХХСангийн зээлдэгч болон санхүүжилтийн судалгаа	14
Дүрслэл 2	ХХСангийн зарцуулалт болон мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн судалгаа	15
Дүрслэл 3	Зээлийн үлдэгдлийн ангилал	17
Дүрслэл 4	Хугацаа хэтэрсэн зээлийн бүтэц	18

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ХХСангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	10
Хүснэгт 2	ХХ Сангийн харилцах дансны үлдэгдэл	11
Хүснэгт 3	ХХСангийн хүний нөөцийн судалгаа	13

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь заалтыг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2024 оны А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн гүйцэтгэлийн аудитыг хийлээ.
Аудитын зорилт	“Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, түүний үр дүн, үр нөлөө, зээлийн эргэн төлөлт”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Үндэсний аудитын газар болон аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: ➤ Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг журмын хүрээнд зохион байгуулсан эсэх, ➤ Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүжүүлсэн төслийн хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх, ➤ Хоршоо хөгжүүлэх санд зээлийн эргэн төлөлт бүрэн төвлөрч байгаа эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Хэнтий аймгийн ЗДТГ, Хөдөө аж ахуйн газар, 18 сумын ЗДТГ, 4 тосгоны Захирагчийн ажлын алба болон хоршоог хөгжүүлэх сангаас олгосон зээл, шинээр бий болсон үйлдвэрлэл, үйлчилгээ, төсөл сонгон шалгаруулах хороо, хяналтын зөвлөл, зээл авсан иргэд, ААН-ийн үйл ажиллагаа, зээлийн эргэн төлөлтийг 2022-2024 оныг дуусталх хугацааг хамруулан аудитыг хийж гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол улсын төрийн аудитын стандарт MNS 6817-7:2020, “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Шалгуур үзүүлэлт	Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав: • Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, • Төсвийн тухай

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого,
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А361 тоот тогтоолоор баталсан “Хоршоог хөгжүүлэх сангийн журам”,
- Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 сарын 03-ны 05 дугаар тогтоолоор баталсан “Хэнтий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”,
- Сумдын хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн хороо болон хяналтын зөвлөл баталсан тушаал шийдвэр,

Аудитыг газрын дарга, Тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа хэрэгжүүлэн ахлах аудитор Д.Эрдэнэбилэг ахлан аудитор Б.Ариунаа, Ц.Хатанболд, Б.Оюундарь нар 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 06 дугаар сарын 02-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Хүндрэл бэрхшээл

.....

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг баталснаар сумдад үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодоор дамжуулан ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилготой хоршоог хөгжүүлэх санг байгуулжээ.

Дээрх журмын хүрээнд ХХС-ийн эх үүсвэрийг Сум хөгжүүлэх сангаас иргэн, аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрөөс бүрдүүлэхээр тусгасан байна. Хэнтий аймгийн хувьд сум хөгжүүлэх сан, жижиг дунд бизнесийг дэмжих сан, Бат-Эрдэнэ сан зэрэг сангуудаас олгосон зээлүүдийг нэгтгэн хоршоог хөгжүүлэх сан болгон зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн А/243 дугаар тушаалаар иргэн, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч гэж нэмсэн, 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/521 дүгээр тушаалаар иргэн, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч гэснийг хасаж журамд нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Аймгийн Засаг дарга орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, хоршоог хөгжүүлэх сургалтыг зохион байгуулж ажиллах үүрэг хүлээсэн байна.

Сумын ИТХ-аар ХХС-ийн үйл ажиллагаа сангийн орлого, зарлага, зээл олгох салбар чиглэл баталж, төсөл сонгон шалгаруулах хороо, хяналтын зөвлөлийг байгуулж, төсөл сонгон шалгаруулах товыг тогтоодог байна.

Төсөл сонгон шалгаруулах хороо нь товын хугацаанд ирсэн төслийг хүлээн авч, хорооны хурлаар хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд сумын Засаг дарга зээл олгох шийдвэрийг баталгаажуулж, зээлийн болон барьцааны гэрээг байгуулж, төслийн явц, үр дүнд байнгын хяналт тавьж, зээлийн эргэн төлүүлэх арга хэмжээ авах, хоршоодод мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

Хяналтын зөвлөл нь зээл авсан хоршооны үйл ажиллагааны, санхүүгийн, зээлийн эргэн төлөлтийн тайланг гаргуулан авах, сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг тухай сумын иргэдэд мэдээлж, ИТХ-ын даргад хүргүүлэх, мөн аймгийн ХХААГ-ын хамт жилд нэгээс доошгүй удаа хяналт шалгалт хийж аймгийн ИТХ-д болон ЖДБҮБХ хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлнэ.

Сумын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь зээлийн мэдээллийг харьяа дээд байгууллагад хүргүүлж, Монгол банкны мэдээллийн санд бүртгүүлэх, төсөл, сонгон шалгаруулах хороо болон хяналтын зөвлөлд нарийн бичгээр ажиллахаар журамлагдсан байна.

ХХСангийн асуудлыг сумын ЗДТГ, тосгоны ЗАА-ны 22 ажилтан хариуцан ажиллаж байгаагаас 9 суманд үндсэн орон тоогоор, 13 сум, тосгонд хавсран гүйцэтгэж байна.

ХХСангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан 994 зээлдэгчийн 5,508.7 сая төгрөгийн зээлийн үлдэгдлийг авч үзвэл СХС-ийн 229 зээлдэгчийн 1,640.5 сая төгрөг, ЖДБДС-ийн 655 зээлдэгчийн 1,276.5 сая төгрөг, ХХСангийн 104 зээлдэгчийн 2,584.6 сая төгрөг, бусад сангийн 6 зээлдэгчийн 6.3 сая төгрөгөөс бүрдсэн байна.

БҮЛЭГ 1. ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХОЛБОГДОХ ЖУРАМ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДААГҮЙ, ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ДУТМАГ БАЙГААГААС ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА

1.1. Орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичигт хоршоог хөгжүүлэх талаар тодорхой тусгаагүй байна.

Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичиг таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөрт эдийн засгийн салбар чиглэлээр жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр тусгасан боловч хоршоог хөгжүүлэх талаар зорилт дэвшүүлээгүй байна.

Суманд ажлын байрыг нэмэгдүүлэх, сангийн хөрөнгийн эргэлтийг сайжруулах, гарааны бизнесийг дэмжих, зээлийн эргэн төлөлтийг хангах, хүлэмжийн аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, малчид, жижиг үйлдвэрлэгчдийг дэмжих, туслах аж ахуй болон зоорийн аж ахуйг хөгжүүлэх зэргээр Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн бодлогыг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэхээр 12 сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрт 27 арга хэмжээг тусгасан байна.

Бусад сумдын Засаг даргын мөрийн хөтөлбөрт хоршоог хөгжүүлэх талаар тодорхой зорилт, чиглэл тусгаадаагүй нь сангийн үйл ажиллагааг сумын дунд хугацааны бодлоготой нийцүүлэн зохион байгуулахгүй байх, хөрөнгийн зарцуулалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хүндрэл үүсэх, бодит хэрэгцээ, хөгжлийн чиг хандлагад нийцээгүй зээлийн шийдвэр гаргах эрсдлийг үүсгэж үүсгэж байна.

Галшар, Баянхутаг, Дархан, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Батширээт, Биндэр, Баян-Адарга, Бор-Өндөр, Мөрөн сум засаг даргын мөрийн хөтөлбөрт хоршоог хөгжүүлэх талаар зорилт тусгаагүй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3.4-т заасны дагуу 14 сумын ИТХ-ын хуралдаанаар хоршоог хөгжүүлэх салбар чиглэлийг баталсан байна.

Гэвч эдгээр сумдын ИТХ хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх салбар чиглэлүүдийг нэгтгэн оновчтой тодорхойлохгүй, олон чиглэлээр баталсан нь бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдаагүй, орон нутгийн онцлог салбарыг хөгжүүлэх зорилтыг хангахгүй байна.

Баянхутаг, Галшар, Дэлгэрхаан, Хэрлэн сумд салбар чиглэлийг батлаагүй боловч Хэрлэн сум 837.0 сая төгрөгийн 24 төсөлд зээл олгосон байна.

Сангийн хөрөнгөөр иргэдийн хоршиж хөдөлмөрлөх идэвх санаачлагыг дэмжих, шинээр ажлын байр бий болгох, ажлын байрыг тогтвортой хадгалах, эрүүл, аюулгүй хүнс, үйлчилгээгээр хангах, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор 2022-2024 онд 107 төсөл хэрэгжүүлэгчид зээл олгосноос 50 нь эрүүл аюулгүй хүнс үйлдвэрлэл, 6 нь түүхий эд бэлтгэх, 51 нь бусад чиглэлийн төсөлд олгогдсон байна.

Бусад чиглэлийн 51 төсөл нь модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээ, арьс ширэн оёмол бүтээгдэхүүн, барилга, авто машин засвар, төмөр эдлэл, хэвлэл болон гар урлал, аялал жуулчлалын салбарт хамаарч байна.

1.2 Сумдад тухайн асуудлыг хариуцсан хүний нөөц дутагдалтай, удирдлага зохион байгуулалт хангалтгүйгээс ХХС-ийн үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулах боломжгүй байна.

ХХС-ийн журмын 2.1¹-д заасны дагуу бүх сумд сангийн эх үүсвэрийг урьд оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, зээл, зээлийн хүү, хугацаандаа төлөгдөөгүй алданги зэргээс бүрдүүлэхээр сумын ИТХ-ын хуралдаанаар батлуулсан байна.

ХХС-ийн 2022 оны санхүүгийн тайланд сумдын ЖДБДС, СХС-аас олгосон 5,433.5 сая төгрөгийн зээл, 2,400.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг нэгтгэн тайлагнасан байна.

Хүснэгт 1: Сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал

Огноо	Орлого				/сая төгрөгөөр/	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /- дутуу, +илүү/	Гүйцэтгэлийн хувь	Зээлийн үлдэгдэл	Зээлийн үлдэгдлээс төвлөрүүлэхээр төлөвлөж байгаа хувь
А	1	2	3=2-1	4=2/1*100%	5	6=1/5*100%
2022	2,074.6	1,004.9	(1,069.8)	48.4%	5,610.9	37.0%
2023	1,451.1	1,170.0	(281.1)	80.6%	5,433.5	26.7%
2024	1,309.7	1,099.7	(210.0)	84.0%	5,901.8	22.2%

Эх сурвалж: ХХС-ийн 2022, 2023, 2024 оны санхүүгийн тайлан

Хүснэгтээс харахад орлогын төлөвлөгөөний биелэлт жил бүр өсөж байгаа боловч төлөвлөлтийг өмнөх оны зээлийн үлдэгдлийн 22.2-26.7%-ийг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 48.4-84.0%-ийг төвлөрүүлсэн нь зээлийн эргэн төлөлтийн хугацаа болсон үлдэгдлийг бүрэн төлөвлөдөггүй, төлөвлөсөн зээлийн үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллахгүй байна.

Батноров, Бэрх, Баянмөнх, Дадал, Хэрлэнбаян-Улаан, Жаргалтхаан, Өмнөдэлгэр сумд 2023 оны орлогын төлөвлөгөөг 100-329%-иар биелүүлсэн боловч зээлийн үлдэгдлийн 8-50%-ийг төвлөрүүлэхээр тооцсон бол 2024 онд Батноров, Батширээт, Баянмөнх, Дадал,

¹ 2.1 Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ: 2.1.1. Улсын болон орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө; 2.1.2. гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив; 2.1.3. сум хөгжүүлэх сангаас иргэн, аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөр; 2.1.4 сангаас аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөр, 2.1.5. хугацаандаа төлөгдөөгүй зээлийн эргэн төлөлтийн төлбөр, 2.1.6 бусад

Дархан, Норовлин сумд 121-258%-иар биелүүлсэн боловч зээлийн үлдэгдлийн 11-45%-ийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 2: Сангийн харилцах дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/				
Огноо	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
А	1	2	3	4=1+2-3
2022	1,497.2	1,682.0	778.7	2,400.6
2023	2,400.6	1,170.0	1,518.6	2,052.0
2024	2,052.0	1,099.7	660.4	2,491.3

ХХС-ийн төрийн сан банкны харилцах дансанд жил бүр 2.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь сангаар дамжуулан иргэдийн хоршиж хөдөлмөрлөх идэвх санаачлалыг дэмжин ажлын байр нэмэгдүүлэх журмын зорилттой нийцэхгүй байна.

Зээл олголтыг 2022 онд 3,906.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 763.3 сая төгрөг, 2023 онд 3,689.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,507.0 сая төгрөг, 2024 онд 3,257.6 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 645.3 сая төгрөгийг олгосон нь төлөвлөлт үндэслэлгүй, хэрэгжилт хангалтгүй байгаагаар холбоотой байна.

Хоршоо эрхлэгчдэд хоршоо болон хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны талаарх чадавхжуулах сургалтыг аймаг, сумын ЗДТГ, ХХААГ-аас 2022-2024 онд 7 удаа, бусад ТББ-аас 8 удаа зохион байгуулсан байна.

Сангийн үйл ажиллагаанд хийгдэх хяналт шалгалт, аудит хийлгэж, дүнг аймгийн ИТХ болон дээд шатны байгууллагад хүргүүлэх ажил хийгдээгүй нь журмын 7.4.3², 7.8³, 7.9⁴ заалтуудыг Аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газар хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Төсөл сонгон шалгаруулах хороог 12 суманд байгуулж, Галшар, Батширээт, Баянмөнх, Баянхутаг, Дэлгэрхаан, Биндэр байгуулаагүй бол Цэнхэрмандал, Дархан, Дадал сумд журамд заасан бүрэлдэхүүнтэй байгуулаагүй нь журмын 4.2 “Хорооны даргаар тухайн сумын Засаг даргын Тамгын газрын дарга, гишүүдээр Санхүү, төрийн сангийн төлөөлөл, хоршоо, ЖДҮҮЭ-ийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан хоёр төрийн бус байгууллагын төлөөлөл байх бөгөөд нарийн бичгийн даргаар сумын хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн байна” гэснийг зөрчсөн байна.

² 7.4.3. аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллагын хамт жилд нэгээс доошгүй удаа сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилт хариуцсан хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлэх.

³ 7.8. Аймгийн жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилт хариуцсан байгууллага сангийн үйл ажиллагаа, орлого, зарлагын гүйцэтгэлд жил бүр хөндлөнгийн аудит хийлгэж, аудитын дүгнэлтийг тухайн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлнэ.

⁴ 7.9. Аймгийн жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилт хариуцсан байгууллага энэ журмын 7.8-д заасан аудитын дүгнэлтийг аймгийн хэмжээнд нэгтгэн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн жилийн 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

Дархан сум Засаг даргын орлогчоор ахлуулсан, Цэнхэрмандал сумд ИТХ-ын 2 төлөөлөгчийг, Дадал сум Төрийн банкны эрхлэгчийг төсөл сонгон шалгаруулах хорооны бүрэлдэхүүнд оруулжээ.

ХХС-ийн хяналтын зөвлөлийг 12 сум байгуулж, Галшар, Батширээт, Баянмөнх, Баянхутаг, Дэлгэрхаан, Биндэр сумд байгуулаагүй, Баян-Овоо сум санхүү төрийн сангийн мэргэжилтэнг томилоогүй, Цэнхэрмандал сум ИТХ-ын 3 төлөөлөгчийг оруулж бүрэлдэхүүнийг томилж журмын заалтыг зөрчсөн байна.

Дээрх 12 сумдын хяналтын зөвлөл нь байгуулагдсан боловч журмаар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ХХС-аас олгох зээлийн төсөл сонгон шалгаруулах товыг 2022-2024 онд 12 суманд журамд заасны дагуу зарласан бол Баян-Овоо, Биндэр, Хэрлэн сумд зарлаагүй байна. Товын дагуу 131 төсөл ирүүлснээс 24 төслийн зээлдэгч болон төсөл нь журмын шаардлага хангаагүй тул буцааж, төсөл сонгон шалгаруулах хороогоор 92 төслийг хэлэлцүүлж, 15 төслийг хэлэлцүүлээгүй байна.

Дархан суманд 2022 онд 90.0 сая төгрөгийн 3 төсөл, Биндэр суманд 2023 онд 12 төсөлд 139.0 сая төгрөгийн зээлийг төсөл сонгон шалгаруулах хороогоор хэлэлцүүлэлгүй олгосон байна.

ХХС-аас 2022 онд 28 иргэн аж ахуйн нэгжид 763.0 сая төгрөг, 2023 онд 66 иргэн, аж ахуйн нэгжид 1,507.0 сая төгрөг, 2024 онд 13 хоршоонд 644.7 сая төгрөг нийт 107 төсөлд 2,914.7 сая төгрөгийн зээл олгожээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-д 2023 оны А/521 дүгээр тушаалаар “хоршоонд” олгохоор өөрчлөлт орсонтой холбоотойгоор 2024 оноос зээл олголт буурсан байна.

ХХС-ийн зээлд хамрагдсан 104 хоршоо, иргэн, компани нь журамд заасан шаардлагыг хангасан бол журамд орсон өөрчлөлтийг мөрдөөгүйгээс Дадал сумын ХХС-аас 2024 онд журмын шаардлагыг хангахгүй 3 иргэнд 46.0 сая төгрөгийн зээл олгосон байна.

Сумдын хоршоог хөгжүүлэх сангаас зээл олгосон хоршоодоос Хэрлэн сумын ХХС-аас олгосон “Оргилох алтан булаг” хоршоо, “Хамтын хүчээр дэвжих” хоршооны санхүүгийн тайлан байхгүй буюу төсөлд хавсаргаж ирүүлэх баримт материалын бүрдлийг хангаагүй, “Аригуна анар” хоршооны төслийн баримт материал байхгүй, бусад төслийн хувьд журмын шаардлага хангасан байна.

ХХСангийн журамд төсөл сонгон шалгаруулах хороо болон хяналтын зөвлөлийн нарийн бичгийн даргаар сумын хоршоо жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллаж:

- ✓ Зээл олгох үйл ажиллагааг зохион байгуулах,
- ✓ Төслийн болон зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих,
- ✓ Монгол банкны зээлийн мэдээллийн санд зээлдэгчийн мэдээлэл оруулах ажлыг хариуцахаар тусгасан байна.

Тухайн асуудлыг сумын ЗДТГ, тосгоны ЗАА-ны 22 ажилтан хариуцан ажиллаж байгаагаас 9 суманд үндсэн орон тоогоор, 13 сум, тосгонд хавсран гүйцэтгэж байна. Уг 22 ажилтаны 3 нь санхүү, эдийн засгийн мэргэжилтэй, 19 ажилтан өөр мэргэжилтэй байна.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа сумын ЗДТГ-ын ажилтануудын албан тушаалын тодорхойлолтод ХХС-г хариуцах ажилтаны гүйцэтгэх чиг үүрэг тавигдах шаардлага тусгагдаагүй байна.

Судалгаа 3: ХХСангийн хүний нөөцийн судалгаа

	Үндсэн орон тоо	Хавсран ажилладаг	Мэргэжил		Ажилласан жил		
			санхүү	бусад	0-5	5-10	10-аас дээш
Хэнтий	9	13	3	18	17	3	2

Сумын ЗДТГ-т хоршоог хөгжүүлэх сангийн ажилтны орон тоо батлагдаагүй, бусад салбарын мэргэжилтэн хавсран ажилладаг, мэргэжлийн хувьд ихэвчлэн хүнс хөдөө аж ахуйн чиглэлийн албан хаагч хариуцан ажилладаг нь ХХС-ийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж хэрэгжүүлэх боломжгүй болгож байна.

1.3 Хяналтын зөвлөл нь хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Хяналтын зөвлөл байгуулагдсан 12 сумдаас Батноров, Мөрөн, Цэнхэрмандал, Дархан, Бор-Өндөр, Жаргалтхаан, Норовлин сумдын хяналтын зөвлөл 2022-2024 онд 10 удаа хяналт хийсэн боловч журмын 7.4-т заасан улирал тутамд хяналт шалгалт хийж, дүнг иргэдэд мэдээлж, ИТХ-д хүргүүлэх чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Тус хяналтын зөвлөл нь сангаас олгосон зээлийн хэмжээ, зориулалт, ангиллыг багтаасан дэлгэрэнгүй мэдээлэл, төслийн хэрэгжилтийн явц ба үр дүн, сангийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн хүрээнд хоршоодод үзүүлсэн дэмжлэг болон түүний үр дүнг тусгасан агуулгатай үйл ажиллагааны тайланг бэлтгэн сумын ИТХ-д хүргүүлэн хэлэлцүүлэх шаардлагатай байна.

Сумдын ХХС-ийн орлого, зарлагыг санхүүгийн тайланд тусган жил бүр хөндлөнгийн аудитаар баталгаажуулан ажилласан байна.

Зээлдэгчдэд зээлийн журмын талаар тодорхой ойлголт өгч сургалт, мэдээллийг зохион байгуулаагүй, хяналт шалгалт хийж, үр дүнг тайлагнаагүйгээс ХХС-аас зээл авсан 14 сумын 107 иргэн, хоршоо, аж ахуйн нэгжүүд нь төслийн үйл ажиллагаа, үр дүнгийн талаар олон нийтэд тайлагнах үүргээ биелүүлээгүй байна.


БҮЛЭГ 2. ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ЗЭЭЛ ОЛГОСОН ТӨСЛИЙН ҮР ДҮНД АЖЛЫН БАЙР НЭМЭГДЭХГҮЙ БАЙНА.

2.1 Төсөл хэрэгжүүлэгч хоршоодын 49.1 хувь нь орон нутагт тогтвортой үйл ажиллагаа явуулахгүй байгаагаас ажлын байр нэмэгдэхгүй байна.

Хоршоог хөгжүүлэх сангаас 2022-2024 онд 4 компани, 44 иргэн, 59 хоршооны нийт 107 төсөлд 2,914.7 сая төгрөгийн зээл олгосноос 67.5 хувийг хоршоодод олгожээ.

Нийт төслийн 61.5 хувь буюу 66 төсөл нь шинээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, 38.5 хувь буюу 41 төсөл нь үйл ажиллагаагаа өргөтгөх, үргэлжлүүлэх зорилгоор зээл авсан боловч тогтвортой үйл ажиллагаа явуулаагүйгээс орон нутагт үйлдвэрлэл үйлчилгээ бий болгох, ажлын байр, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зорилт бүрэн хэрэгжихгүй байна.

Дүрслэл 1: ХХСангийн зээлдэгч болон санхүүжилтийн судалгаа



Хоршоог хөгжүүлэх сангаас санхүүжүүлсэн 2,118.7 сая төгрөгийн 78 төслийн үйл ажиллагаа тогтвортой явагдаж байгаа бол 796.0 сая төгрөгийн 29 төсөл нь хэрэгжиж дуусаагүй, үйл ажиллагаа явуулсан эсэх нь тодорхойгүй зэргээр сангийн санхүүжилтийн үр дүнг бууруулж байгаа нь төсөл сонгон шалгаруулах хороо төслийг эрэмбэлэх, үнэлэх ажлыг хангалтгүй хийсэнтэй холбоотой

байна.

Сангаас санхүүжүүлсэн 107 төслийг хэрэгжүүлэгчдийн 55.3 хувь буюу 59 нь хоршоо бөгөөд эдгээрээс 30 нь тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

Сангийн үндсэн зорилгын хүрээнд хоршоодоор дамжуулан суманд эрүүл аюулгүй хүнс үйлдвэрлэх, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог нэмэгдүүлэхээр 54 төсөлд санхүүжилт олгосноос 48 төсөл нь мал аж ахуй, цагаан идээ, хүнсний ногоо, махан бүтээгдэхүүн боловсруулах, сүү үйлдвэрлэх, 6 төсөл нь түүхий эд бэлтгэлтийн тогтолцоог бүрдүүлэх, хоёрдогч түүхий эд боловсруулахад чиглэгдсэн байна.

Сангийн журмын 7.11-д заасан бусад чиглэлийн 53 төсөлд зээл олгосон нь ажлын байр бий болгож, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх журмын зорилгыг хангахгүй байна.

Хоршоог хөгжүүлэх сангийн санхүүжилтээр тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа 78 төсөл нь нийт 286 ажлын байр бий болгосноос 138 нь шинээр, 148 нь хадгалагдсан ажлын байр байна. Үүнээс 51 төслийг хэрэгжүүлэгч НДШ төлж байгаа нь ажлын байр бий болох, иргэдийн орлого нэмэгдэх, амьжиргаа сайжирсан гэж үзэх боломжгүйд хүргэж байна.

ХХС-аас 14 иргэн, 1 компани, 14 хоршоо нь нийт 29 төсөлд 796.0 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч тогтвортой үйл ажиллагаа явуулаагүй, төслийн үр дүн хангалтгүй байна.


2.2 Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан боловч эх үүсвэрийг бүрэн ашиглахгүй байна.

Хэнтий аймгийн хэмжээнд 2022-2024 онд хоршоог хөгжүүлэх сангийн эх үүсвэрийн 97.6%-99.2% буюу 763.2-1,507.0 сая төгрөгийг зээлд, 0.8%-2.4% буюу 11.5-15.7 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулсан нь журамд нийцэж байгаа боловч хоршоог хөгжүүлэх сангийн сургалтад хамрагдсан гишүүд өөрсдийн томилолтоо харьяалах албан байгууллагаас бус сангаас авч байгаа нь цаашид сангийн үйл ажиллагааны зардалд тусгагдаагүй зардалд зарцуулах нь давтагдаж болзошгүй байна.

Цэнхэрмандал сумын хоршоог хөгжүүлэх сангаас 2023 онд 520.0 мянган төгрөг, 2024 онд 472.0 мянган төгрөгийг сумын ЗДТГ-ын гишүүд хоршооны сургалтын албан томилолтод авсан байна.

Хоршоог хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 2022 онд 24.5% буюу 778.7 сая төгрөг, 2023 онд 42.5% буюу 1,518.6 сая төгрөг, 2024 онд 21.0% буюу 660.4 сая төгрөгийг зарцуулж, 2024 оны жилийн эцсийн байдлаар 2,491.3 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байна.

Дүрслэл 2: ХХСангийн зарцуулалт болон мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн судалгаа



Орон нутагт байгуулагдсан хоршоод журмын шалгуурыг хангахгүй, хоршоодоос ирүүлсэн төсөл нь журмын шаардлагад нийцэхгүй, хугацаа хоцордог, сумын Засаг даргаас зээлийн үлдэгдлийг бүрэн төвлөрүүлсний дараа зээл олгохоор чиглэл баримталсны улмаас мөнгөн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдэл хуримтлагдсан байна.

Хоршоог хөгжүүлэх сангаас 2022-2024 онд нийт 2,914.7 сая төгрөгийн санхүүжилтийг 107 хоршоо, иргэн, аж ахуйн нэгжид олгосноос 1,592.2 сая төгрөгийн 62 төслийг төсөл сонгон шалгаруулах хороогоор хэлэлцэн, 1,195.0 сая төгрөгийн 42 төслийг хэлэлцүүлэлгүй, 130.0 сая төгрөгийн 3 төслийг Засаг даргын шийдвэргүйгээр тус тус олгосон байна. Үүнээс:

- ХХСангаас 2022 онд Дархан сум 3 төсөлд 90.0 сая төгрөг, Баян-Овоо сум 1 төсөлд 30.0 сая төгрөг, 2023 онд Биндэр сум 12 төсөлд 139.0 сая төгрөгийг төсөл сонгон шалгаруулах хорооны шийдвэргүй олгосон байна.
- Батширээт сум 2 төсөлд 99.0 сая төгрөг, Хэрлэн сум 24 төсөлд 837.0 сая төгрөгийн зээлийг холбогдох шийдвэргүй олгожээ,
- Норовлин сумын 3 төсөлд 130.0 сая төгрөгийг хорооны шийдвэрийг баталгаажуулаагүй зээл олгосон байна.

ХХС-аас 2,914.7 сая төгрөгийн зээлийг 107 төсөлд олгосноос төсөл сонгон шалгаруулах хорооны шийдвэрээс санхүүжилт хүрэлцэхгүй шалтгаанаар Өмнөдэлгэр, Дадал сумд 5 төсөлд олгох зээлийг 2.5 сая төгрөгөөр бууруулж олгосон байна.

Сумд хоршоог хөгжүүлэх сангийн 2022-2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гарган аймаг дахь Төрийн аудитын байгууллагаар баталгаажуулсан байна.

Сумдын Хоршоог хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд тусгагдсан авлагын үлдэгдэл ХХААХҮЯ-ны хяналтын программын үлдэгдэлээс 2022 онд 1,533.2 сая төгрөг, 2023 онд 1,266.3 сая төгрөг, 2024 онд 1,203.2 сая төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан нь ЖДБДБС болон бусад сангийн эх үүсвэрийг ХХААХҮСайдын 2021 оны №А/361 тоот тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2.1⁵-д заасан сангийн эх үүсвэрт нийцэхгүй тул ХХААХҮЯ-ны хяналтын программд бүртгээгүй нь авлагын дүн зөрөх шалтгаан болсон байна.

⁵ 2.1. Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

2.1.1. Улсын болон орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;

2.1.2. гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив;

2.1.3.сум хөгжүүлэх сангаас иргэн, аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөр;

2.1.4. сангаас аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөр;

2.1.5. хугацаандаа төлөгдөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги;

2.1.6. бусад;

Аймгийн хэмжээнд ЖДБДС-ийн 1,220.7 сая төгрөгийн 635 зээлдэгч, СХС-ийн 10.2 сая төгрөгийн 1 зээлдэгч, Бат-Эрдэнэ сангийн 6.3 сая төгрөгийн 6 зээлдэгчийн мэдээлэл ХХААЯамны хяналтын системд бүртгэгдээгүй байна.

БҮЛЭГ 3. САНГИЙН ХУГАЦАА ХЭТЭРСЭН ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ НЬ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАНГАХГҮЙ БАЙНА.

3.1 Сангийн нийт зээлийн үлдэгдлийн 58.0% буюу 3,224.5 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн зээл байна.

ХХС-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан 994 зээлдэгчийн 5,516.0 сая төгрөгийн зээлийн үлдэгдлийн 42.0% буюу 2,291.5 сая төгрөг нь хэвийн төлөлттэй, 58.0% буюу 3,224.5 сая төгрөгийн зээл нь гэрээний хугацаанд төлөгдөөгүй байна.

Хугацаандаа төлөгдөөгүй зээлийн үлдэгдлийг активын ангиллаар авч үзвэл 25.4 сая төгрөгийн 1 зээл анхаарал хандуулах, 40.9 сая төгрөгийн 3 зээл эргэлзээтэй, 1,921.0 сая төгрөгийн 251 зээл муу ангилалтай бол 1,237,2 сая төгрөгийн 642 зээл хугацаа хэтэрсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам" батлагдсанаас хойш олгосон зээлээс 2024 оны жилийн эцсийн байдлаар 104 зээл 2,585.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Дүрслэл 3: Зээлийн үлдэгдлийн ангилал



Зээлийн үлдэгдлийг активын ангиллаар авч үзвэл 2,280.0 сая төгрөгийн 95 зээл хэвийн, 25.4 сая төгрөгийн 1 зээл анхаарал хандуулах, 32.2 сая төгрөгийн 2 зээл эргэлзээтэй, 247.6 сая төгрөгийн 6 зээл муу ангилалтай байна. Гэрээний хугацаанд зээлийн төлбөрийг төлөөгүй буюу хугацаа хэтэрсэн зээл нийт зээлийн 11.0 хувийг эзлэж байгаа нь журамд заасан сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангахгүй байна.

Хяналтын зөвлөл нь зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллаагүйтэй холбоотой байна.

ХХААХҮЯ-ны хяналтын программд бүртгэгдсэн 2022 онд 3,900.3 сая төгрөг, 2023 онд 4,634.5 сая төгрөг, 2024 онд 4,312.8 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл нь Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгэгдсэн байна.

ХХС-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан 994 зээлдэгчийн 5,516.0 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл нь Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллээс 642 зээлдэгчийн 1,203.2 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь хоршоог хөгжүүлэх сан байгуулагдсанаас өмнөх СХС-аас олгосон 10.2 сая төгрөгийн 1 зээл, ЖДБДС-аас олгосон 1,193.0 сая төгрөгийн 641 зээлийн үлдэгдэлтэй холбоотой байна.

ЖДБДСангаас олгосон зээлийн гэрээнд Зээлийн мэдээллийн тухай хуулийн 5.1.2 “Зээлдэгчийн зөвшөөрлийг заавал авсан байх” зарчмыг тусгаагүйтай холбоотойгоор Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгүүлэх боломжгүй байдал үүссэн байна.

Галшар, Баянхутаг, Баян-Адарга, Дадал, Дэлгэрхаан, Өмнөдэлгэр, Хэрлэн сумдад ЖДБДС болон СХСангаас 20 иргэнд давхардуулан 135.7 сая төгрөгийн 41 зээл олгогдсон боловч Хоршоог хөгжүүлэх сангаас давхардуулан зээл олгоогүй байна.

Аудитын хүрээнд эрх зүйн баримт бичгийг судлан үзэхэд Хоршоог хөгжүүлэх сан нь Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.4 дэх хэсэгт заасны дагуу 60 дугаар зүйлд Орон нутгийн хөгжлийн сантай байхаар зохицуулсан байх тул орон нутгийн тусгай сан гэж үзэх боломжгүй байна.

Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасан тусгай сангийн төрөлд хамаарахгүй байна.

Иймд Хоршоог хөгжүүлэх сангаас зээл олгож байгаа нь Төсвийн тухай хуулийн 24¹ дүгээр зүйлийн 24¹.1-ийн 2 дахь хэсэгт заасантай зөрчилдөж байна.

3.2 Сангийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хангалтгүй байна.

Сумдын ХХС-ийн хугацаа хэтэрсэн зээлийг эргэн төлүүлэх арга хэмжээний хүрээнд сумын хоршоо хариуцсан мэргэжилтэн 1,550.1 сая төгрөгийн 334 зээлдэгчид 468 удаа мэдэгдэлийг хүргүүлж, 1,290.7 сая төгрөгийн 250 зээлдэгчдийн зээлийг эргэн төлүүлэх талаар шүүхийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлсэн байна.

Харин Баянмөнх, Дархан, Норовлин сумын ХХС-ийн хяналтын программд бүртгэлтэй зээлийн үлдэгдэл нь 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаарх зээлийн үлдэгдлээс 7.3 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Үүнд:

ХХС-ийн зээлийн үлдэгдлийг Баянмөнх сумын 8.5 сая төгрөгөөр дутуу, Дархан, сум 0.2 сая төгрөг, Норовлин сум 1.0 сая төгрөгөөр тус тус илүү тайлагнасан байна.

Зээлдэгчийг гэрээний үүргээ биелүүлээгүй буюу эрсдэл үүссэн тохиолдолд зээлийн хөрөнгийг эргүүлэн татах ажиллагааг сумдын Засаг дарга болон хяналтын зөвлөл хариуцан зохион байгуулах үүргээ биелүүлээгүй байна.

ХХС-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан 994 зээлдэгчийн 5,516.0 сая төгрөгийн зээлийн үлдэгдлээс 3,217.8 сая төгрөгийн 897 зээлийн гэрээний хугацаа дууссанаас 313.8 сая төгрөгийн 93 зээлдэгчийн зээл төлөгдсөн бол 2,903.4 сая төгрөгийн 804 зээлдэгчийн зээл төлөгдөөгүй байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг авч



үзвэл шүүхийн шийдвэр гарсан боловч төлөгдөөгүй 173 зээлдэгчийн 691.1 сая төгрөг, холбогдох баримт материал байхгүй 46 зээлдэгчийн 138.9 сая төгрөг, эрэн сурвалжлах шийдвэр гарсан 36 зээлдэгчийн 121.1 сая төгрөг, холбогдох арга хэмжээг аваагүй 458 зээлдэгчийн 1,670.8 сая төгрөгийн зээл байна.

Мөн 206.1 сая төгрөгийн 60 зээлдэгч нас барсан, шүүх хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул хүлээн аваагүй, шүүхийн шийдвэр гараагүй 39.8 сая төгрөгийн 13 зээл, 18 зээлдэгчийн 35.6 сая төгрөгийн зээлд мал болон тоног төхөөрөмж тооцон авсан байна.

Бор-Өндөр сумын Хоршоог хөгжүүлэх сангаас 2023 онд олгосон зээлийг хугацаанд нь төлөөгүй 1 зээлдэгчид 0.4 сая төгрөгийн алданги ногдуулж төлүүлсэн бол бусад сумдад хугацаа хэтэрсэн зээлд алданги тооцоогүй байна. Энэ нь журамд заасны дагуу зээлийг хугацаандаа төлөөгүй бол зээлийн үлдэгдлээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд алданги ногдуулах тухай гэрээнд тусгасан заалтын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Холбогдох байгууллагын санал:



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23000
Утас/Факс: (976) 7056 2151,
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

2025.05.30 № 9/1246
танай _____-ны № _____-т

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа,
түүний үр дүн, үр нөлөө, зээлийн эргэн төлөлт”-д хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.
Холбогдох санал байхгүй болно.



233050504

Саналд өгсөн тайлбар:

Аудитын тайланд санал ирүүлээгүй тул өөрчлөлт ороогүй

Гүйцэтгэлийн аудитаар нийт 4,445.6 сая төгрөгийн 15 зөрчил илрүүлснээс 259.0 сая төгрөгийн 2 албан шаардлагыг аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газарт, зөрчил арилгах 4,186.6 сая төгрөгийн 6 зөвлөмжийг аймгийн Засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлж, аудитын дүнд үндэслэн 1 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт хоршоог хөгжүүлэх талаар зорилт дэвшүүлээгүй, орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тогтоогоогүй байна.
- Аймгийн Засаг дарга, ХХААГ нь хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллаагүй байна.
- Сумын ИТХ нь төсөл сонгон шалгаруулах хороо, хяналтын зөвлөл байгуулах чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс 6 суманд хороо, зөвлөл байгуулагдаагүй байна.
- Сумын ЗДТГ-т хоршоог хөгжүүлэх сангийн ажилтны орон тоо батлагдаагүй, мэргэжлийн хувьд санхүү, эдийн засгийн бус, бусад салбарын мэргэжилтэн хавсран гүйцэтгэдэг нь сангийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж хэрэгжүүлэх боломжгүй болгож байна.
- Хоршоог хөгжүүлэх сангаас зээл олгосон төслийн 27% буюу 796.0 сая төгрөгийн 29 төслийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь сангийн хөрөнгийн үр дүнг бууруулж байна.
- Дархан, Баян-Овоо, Биндэр сумын Засаг дарга нар нь төсөл сонгон шалгаруулах хорооны шийдвэргүйгээр 17 төсөлд 259.0 сая төгрөгийн зээл олгосон байна.
- Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайланд бүртгэгдсэн зээлийн 58% буюу 3,224.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн чанаргүй зээл байна.
- Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайланд 5,516.0 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл, 2,491.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулсан байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Д.Аюурбунь-д:

- Аймгийн хоршоо хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг дунд хугацааны бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах,
- Сумдын хоршоог хариуцсан хүний нөөцийг бүрдүүлж, чадавхжуулах, мэргэжил арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулах,
- Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах,

Аймгийн ХХААГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Гантөмөр-т:

- Төрөөс хоршоо, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх талаар баримталж буй бодлоготой уялдуулан, аймгаас тогтоосон тэргүүлэх чиглэлийн хүрээнд хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах ажиллах, үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах,
- Хоршоодод мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах,
- Сумын Хоршоо хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөлтэй хамтран сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүнг аймгийн ИТХ-д хүргүүлэх,

Аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг “Төрийн аудитын тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд ирүүлнэ үү.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

1. Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.4 дэх хэсэгт заасны дагуу 60 дугаар зүйлд Орон нутгийн хөгжлийн сантай байхаар хуульчилсан тул хоршоог хөгжүүлэх санг орон нутгийн тусгай сан гэж үзэх боломжгүй байна. Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасан тусгай сангийн төрөлд хамаарахгүй байна. Хоршоог хөгжүүлэх сангаас зээл олгож байгаа нь Төсвийн тухай хуулийн 24¹ дүгээр зүйлийн 24^{1.1}-ийн 2 дахь хэсэгт заасантай зөрчилдөж байна.
2. ХХС-аас санхүүжүүлсэн төслийн үр дүн хангалтгүй, сангийн үйл ажиллагааг хариуцах орон тооны санхүү, эдийн засгийн мэргэжлийн ажилтан дутагдалтай, журмын хэрэгжилт хангалтгүй, чанаргүй зээлийн эзлэх хувь өндөр байна.

Иймд уг санг төрийн байгууллагын эрхлэх асуудлаас гарган холбогдох банк, санхүүгийн байгууллагад шилжүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх саналтай байна.



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 05 дугаар сарын 30

Дугаар 184 - А2341314

Чингис хот

ХЭА - 2025/53 - ШТА - ГА

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, түүний үр дүн, үр нөлөө, зээлийн эргэн төлөлт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дархан сум 2022 онд 3 төсөлд 90.0 сая төгрөг, Баян-Овоо сум 1 төсөлд 30.0 сая төгрөг, Биндэр сум 2023 онд 12 төсөлд 139.0 сая төгрөгийн санхүүжилтийг төсөл сонгон шалгаруулах хорооны шийдвэргүйгээр олгосон байна.

Энэ нь Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 6.6.Төсөл сонгон шалгаруулах хороо нь энэ журмын 6.3, 6.4-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянаж, 6.4-т заасан шалгуураар хорооны гишүүн тус бүр оноогоор дүгнэн, дундаж оноогоор эрэмбэлэн жагсаалт батална. Энэхүү шийдвэрээ ажлын 3 хоногийн дотор тухайн сумын Засаг даргад хүргүүлнэ.” 6.7. “Төсөл сонгон шалгаруулах хорооны шийдвэрийг тухайн сумын Засаг дарга хүлээн авч баталгаажуулан, эрэмбэлсэн жагсаалтын дагуу санхүүжүүлнэ” гэснийг зөрчсөн байна.

Иймд “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөл сонгон шалгаруулах хорооны шийдвэргүйгээр зээл олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аймгийн засаг дарга Д.Аюурбуньд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.АНБААТАР

Б.ОЮУНДАРЬ

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 05 дугаар сарын 30

Дугаар 188-А2360446

Чингис хот

ХЭА - 2025/53 - ШТА - ГА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, түүний үр дүн, үр нөлөө, зээлийн эргэн төлөлт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дархан сум төсөл сонгон шалгаруулах хороог Засаг даргын орлогчоор ахлуулсан, Цэнхэрмандал сум ИТХ-ын 2 төлөөлөгч, Дадал сум Төрийн банкны эрхлэгчийг төсөл сонгон шалгаруулах хорооны бүрэлдэхүүнээр томилсон. Мөн Баян-Овоо сум санхүү төрийн сангийн мэргэжилтэнгүй, Цэнхэрмандал сум ИТХ-ын 3 төлөөлөгч оролцуулан хяналтийн зөвлөлийг байгуулсан. Галшар, Дэлгэрхаан, Биндэр, Батширээт, Баянмөнх, Баянхутаг зэрэг сумд төсөл сонгон шалгаруулах хороо болон хяналтын зөвлөлийг байгуулаагүй байна.

Энэ нь Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.1.1. “Сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг төрөөс хоршоо, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх талаар баримталж буй бодлоготой уялдуулан нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах”, 4.1. “Хороо болон хяналтын зөвлөл тус бүр нь дарга, гишүүд, нарийн бичгийн даргаас бүрдсэн таван хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд зөвлөлийн нарийн бичгийн даргаас бусад гишүүдийг давхардуулан ажиллуулахгүй”, 4.2. “Хорооны даргаар тухайн сумын Засаг даргын Тамгын газрын дарга, гишүүдээр Санхүү, төрийн сангийн төлөөлөл, хоршоо, ЖДҮҮЭ-ийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан хоёр төрийн бус байгууллагын төлөөлөл байх бөгөөд нарийн бичгийн даргаар сумын хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн байна”, 4.3. “Хяналтын зөвлөлийн даргаар тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, гишүүдээр санхүү, төрийн сангийн мэргэжилтэн, аймгийн хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, төрийн бус байгууллагын төлөөлөл байх бөгөөд нарийн бичгийн даргаар сумын хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн байна” гэснийг зөрчсөн байна.

Иймд “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй

гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сумд төсөл сонгон шалгаруулах хороо болон хяналтын зөвлөлийг журамд заасан бүрэлдэхүүнээр байгуулж, биелэлтийг 2025 оны 9 дугаар сарын 10-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Гантөмөрт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Х.ГАНБААТАР

Д.ЭРДЭНЭБИЛЭГ

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112

АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛ

Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, түүний үр дүн, үр нөлөө, зээлийн эргэн төлөлт
ХЭА-2025/53-ЦГА-ГА

Аудитын нэр:
Аудитын код:

Байгууллагын нэр: Хэнтийн аймаг ТАГ

№	Аудитын чиглэл, асуулт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
Аудитын дэд зорилт 1. ХХСангийн үйл ажиллагааг журмын хүрээнд зохион байгуулж байна уу?						
1.1. Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа нь дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасдан зорилттой уялдаж байна уу?						
1	1.1.2. Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа нь аймаг, сумын бодлогын баримт бичигт туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэж байна уу?	Аймгийн хэмжээнд орон нутгийн хийж, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг, Баянхутаг, Галшар, Дэлгэрхаан, Хэрлэн сумд санаас эзэл олгох салбар, чиглэлийг батлаагүй байна.	-	Зөвлөмж 1: Аймгийн хоршоо хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг дунд хугацааны бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах		
1.2. Сангийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөж, үйл ажиллагааг зохион байгуулж байна уу?						
2	1.2.2 Сангийн үйл ажиллагааны талаар хариуцсан төрийн захиргааны байгууллагууд удирдлага зохион байгуулалтаар бүрэн хангаж ажилласан уу?	Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа сумын ЗДТГ-ын ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтод ХХС-г хариуцах ажилтны гүйцэтгэх чиг үүрэг тавигдах шаардлага тусгаагүй, 13 сум, тосгонд уг ажлыг хавсран гүйцэтгэж байна.	-	Зөвлөмж 2: Сумдын хоршоог хариуцсан хүний нөөцийг бүрдүүлж, чадавхижуулах, мэргэжил арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулах		
3	1.2.4 Зээлийн хорооны бүрэлдэхүүнийг журмын дагуу батлуулж ажилласан уу?	Дархан сум Засаг даргын орлогчоор ахлуулсан, Цэнхэрмандал сум ИТХ-ын 2 төлөөлөгч, Дадал сум Төрийн банкны эрхлэгчийг төсөл сонгон шалгаруулах зээлийн хорооны бүрэлдэхүүнд багтасан нь журмын 4.2-т заасныг зөрчсөн, Галшар, Баянхутаг, Баянмөнх, Биндэр, Батширээт, Дэлгэрхаан сум зээлийн хороог байгуулаагүй байна.	-	Албан шаардлага 1: Сумын төсөл сонгон шалгаруулах хороо, хяналтын зөвлөлийг журмд заасан бүрэлдэхүүнээр байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж зохион байгуулах арга зүйгээр хангах		
4	1.2.5 Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн журмын дагуу батлагдсан байна уу?	Дархан, Цэнхэрмандал сум журмд заасан бүрэлдэхүүнээр томилогүй, Галшар, Баянхутаг, Баянмөнх, Биндэр, Батширээт, Дэлгэрхаан сум хяналтын зөвлөлийг огт байгуулаагүй байна.	-			
5	1.2.6 Төсөл сонгон шалгаруулах хороо сонгон шалгаруулах үнэлэх үйл аяцыг журмын дагуу ил тод нээлттэй зохион байгуулсан уу?	Дархан сум 2022 онд 3 эзэлд 90.0 сая төгрөг, Биндэр сум 12 эзэлд 139.0 сая төгрөг нийт 15 эзэлд 229.0 сая төгрөгийг төсөл сонгон шалгаруулах хороогоор хэлэлцүүлээгүй байна	-			
6	1.2.7 Санаас эзэл олгосон хоршоо нь журмын шаардлагыг хангасан байна уу?	Дадал сумын ХХС-гаас 2024 онд журмын шаардлагад нийцээгүй 3 иргэнд 46.0 сая төгрөгийн зээл олгосон байна.	46,000,000.0	Зөвлөмж 3: Төрөөс хоршоо, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх талаар баримталж буй бодлоготой уялдуулан, аймгаас тогтоосон тэргүүлэх чиглэлийн хүрээнд хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах, үйл ажиллагааг олон нийтэд сурталчилгах		
7	1.2.8 Санаас эзэл олгосон төсөл нь журмын шаардлагыг хангасан байна уу?	ХХС-аас олгосон Хэрлэн сумын 55.0 сая төгрөгийн 2 төсөлд санхүүгийн тайлан, 15.0 сая төгрөгийн 1 төслийн баримт материал байгууль байгаа нь журмын 5.5-д заасныг зөрчсөн байна.	-			
1.3. Сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлж байна уу?						
8	1.3.1 Сумын ХХСангийн хөрөнгийн зарцуулалттай байнгын хяналт тавьж, үр дүнг байжруулах арга хэмжээ авч ажилласан уу?	ХХС-аас эзэл авсан 14 сумын 107 иргэн, хоршоо, аж ахуйн нэгжүүд нь төслийн үйл ажиллагаа, үр дүнгийн талаар олон нийтэд тайлагнах үүргээ биелүүлээгүй байна.	-			
9	1.3.2 Хяналтын зөвлөл сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавьж тайлагнасан байна уу?	8 сумын хяналтын зөвлөл журмд заасны дагуу хяналт шалгалт хийгээгүй бол нийт сумд журмд заасны дагуу улирал тутам хяналт шалгалт хийгээгүй, дүнг тайлагнах ажил хийгээгүй байна.	-	Зөвлөмж 4: Сумын Хоршоо хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөлтэй хамтран сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүнг аймгийн ИТХ-д хүргүүлэх,		
10	1.3.3 Аймгийн ХХСангийн үйл ажиллагаанд жил бүр хөндлөнгийн аудит хийдэг, аудитын дүгнэлтийг аймгийн Нутгийн удирдах байгууллагаар хэлэлцүүлсэн уу?	Аймгийн ХХААГ нь сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй, дүгнэлтийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлээгүй байна.	-			

Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг,
Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхарт
Утас: +976 70562112
И-мэйл хаяг: khentii@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn